

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Сайн Байцгаана уу,

Бага Сургуулийн хамт олон маань Хаврын Жүжигчилсэн тоглолтондоо бэлтгээд завгүй байна. Та бүхэн цаг гарган хүрэлцэн ирж манай сурагчдын тоглолтыг үзнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ долоо хоногт 10-р ангийн сурагчид бие дааж хийсэн төслийн тайлангаа амжилттай хамгааллаа. Тайлан хамгаалалтанд оролцож сурагчдын презентацийг сонсож байхад шилдэг боловсрол амжилттай эзэмшихийн төлөө сурагчид маань мэрийн суралцаж байгаа нь тодорхой харагдаж байлаа. Төслийн тайлангаа амжилттай хамгаалсан сурагчиддаа болон төслийг удирдсан багш нартаа баяр хүргэе.

Энэ сарын сүүлээр бид номтой нөхөрлөх 7 хоног арга хэмжээг зохион байгуулах гэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг номын санчид та бүхэнд удахгүй хүргэх болно.

Та бүхэн гэрийнхээ номын санг янзалж байхдаа хэрэглэхгүй илүү ном байвал манай номын санд хандивлаарай. Олон орны хэл дээр бичигдсэн хүүхдийн номнууд бидэнд хэрэгтэй байх болно. Та бүхэн томчуудад зориулсан буланд байгаа уран зохиолын номнуудаас авч уншиж болно. Энэ буланд зориулж та бүхэн бас ном хандивлавал бид дуртайяа хүлээн авах болно.

Та бүхнийг Хүндэтгэсэн,

**Захирал, Greg Rayl**

### **ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:**

3 сарын 5	Бага Сургуулийн сурагчид кино үзнэ
3 сарын 8	Олон улсын Эмэгтэйчүүдийн Баярын өдөр-Хичээл орохгүй
3 сарын 17	Дипломын Хөтөлбөрийн талаар мэдээлэл хийх уулзалт
3 сарын 18	Бага Сургуулийн Сурагчдын Жүжигчилсэн Тоглолт
3 сарын 22	Бага Сургуулийн Хөтөлбөр/Сурагчдын удирдаж явуулах хурлын талаар мэдээлэл өгөх уулзалт
3 сарын 31	Сурагчдын удирдаж явуулах хурал (тодорхой хуваарийг дараа явуулна)

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Энэ долоо хоногт 10-р ангийн сурагчид маань Бие Дааж хийсэн төслийн тайлангаа амжилттай хамгааллаа. Тайлан хамгаалалтанд хүрэлцэн ирсэн эцэг эхчүүд болон багш нар, сурагчиддаа баярлалаа. 9-р ангийн сурагчид ирэх жил юуг анхаарах ёстой талаар их зүйлийг сурч авсан гэдэгт би итгэлтэй байна. Энэ бол тайлан хамгаалалтын нэг чухал хэсэг байсан.

10-р ангийн сурагчдын хувьд Бие Дааж хийдэг энэ Төсөл нь МҮР хөтөлбөрийн нэг чухал хэсэг байдаг. Сурагчид маань тайлан хамгаалалтаа сайн хийсэнд бид баяртай байна. Сурагчдын төслийн Зөвлөхөөр ажилласан багш нартаа талархал илэрхийлье. Тэдний дэмжлэг, зөвлөлгөөгүйгээр сурагчид маань төслөө амжилттай гүйцэтгэхгүй байх байсан. Би МҮР Хөтөлбөрийн Зохицуулагч David Chilton-д онцгойлон талархал илэрхийлэхийг хүсэж байна. Багш сурагчдыг төслийн ажлаа хугацаанд нь амжилттай гүйцэтгэхэд Mr. Chilton ихээхэн анхаарал тавьж ажилласан.

Даваа гарагт нийтээр амрах баярын өдөр тул хичээл орохгүй. 3 сарын 9-ны Мягмар гарагт хичээл орно. Даваа гарагт Олон Улсын Эмэгтэйчүүдийн Баярын Өдрийг Монголчуудын хамт манай сургууль тэмдэглэж энэ өдөр хичээл орохгүй сургууль амарна. Та бүхэн амралтаа сайхан өнгөрүүлээрэй.

**Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann**

### **8-р ангийн сурагчдын Fashion Show**

Өнгөрсөн Баасан гарагт 8-р ангийн сурагчид Франц хэлний хичээлээр судалж байгаа сэдвийн хүрээнд Fashion Show зохион байгуулсан. Тэд цаг агаар ба хувцаслалт сэдэв үзэж “ISU Fashion” show зохиохоор шийдсэн. Сурагч тус бүр 2 хувцас өмсөхөөр сонгож сонгосон хувцсаа тайлбарлах

даалгавартай байсан. 8-р ангийн сурагчид энэ арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Та бүхэнд баярлалаа.

**Франц хэлний багш Hilde Berg**

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

### **Charlie and the Chocolate Factory**

3 сар аль хэдийн гараад явж байна гэдэгт та бүхэн итгэж байна уу! Хаврын уур амьсгал ороод манай Бага сургуулийн хамт олны тоглолт болох хугацаа дөхсөөр байна. Тоглолт 3 сарын 18-ны Пүрэв гарагт ОУДС-ийн заланд 19:00 цагт болно. Манай хамт олон бүгдээрээ тоглолтын бэлтгэл ажлаа хийгээд завгүй байна. Тоглолтын тайз засал, хувцас хийх ажилд тусалж байгаа эцэг эхчүүддээ дахин талархал илэрхийлье! Манай туслах багш нар тоглолтын хувцсыг өөрсдөө оёж, хийж байгаа. Бид тоглолтын хувцсыг аль болох өөрсдөө хийх зорилготой байгаа хэдий ч эцэг эхчүүд гэрээсээ зарим зүйлийг авчирч өгвөл сайн байна. Жишээ нь: Тухайн дүрийн хувцаслалтаас шалтгаалж пүз, костюм, даашинз зэрэг зүйлс бидэнд хэрэгтэй байгаа. Хүүхдэд тань ямар хувцас шаардлагатай байгаа талаарх мэдээллийг бид сурагчдад өчигдөр өгч явуулсан. Хэрвээ та бүхэнд асууж лавлах зүйл байвал надтай e-мэйлээр холбоо бариарай: [k.carroll@isumongolia.edu.mn](mailto:k.carroll@isumongolia.edu.mn)

**Одон Орон Ажиглах Орой:** Өнгөрсөн Баасан гарагт 3-р ангийн сурагчид одон орны ажиглалт хийсэн. Аз болоход тэнгэр цэлмэж сурагчид телескопоор сарыг ажиглах боломжтой байлаа. Тэд эцэг эхчүүддээ презентация үзүүлж халуун шоколад ууж хөнгөн зууш амтархан идсэн. Mrs. Covington-д тусалж сурагчидтай өөрсдийн туршлагаасаа хуваалцсан Dr. Jenner, Mr. Larrison нарт талархал илэрхийлье.

**Тооны Хичээл:** Хичээлийн жилийн 100 дахь өдөр ойртож байна. Ангиуд 100 дахь өдөрт зориулж төрөл бүрийн жижиг төслийг сурагчдаар хийлгэж байна. Сурагчид зуугийн тоог төлөөлсөн төрөл бүрийн сонирхолтой зүйлс хийж авчирч байгаа бөгөөд 3 сарын 15-ны Даваа гарагт бид хичээлийн жилийн 100 дахь өдрийг тэмдэглэх болно.

**Номтой нөхөрлөх 7 хоног** удахгүй болно. 3 сарын 29-4 сарын 2-ны долоо хоногт бид олон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ үеэр Канадын хүүхдийн зохиолч Margriet Ruurs манай сургуульд айлчилж ангиудаар зочилж сурагчидтай хамт ном уншин, бага хурал зохион байгуулна. Гуравдугаар сарын туршид сурагчид Read-a-thon-д оролцож Монголд номтой нөхөрлөх ажлыг дэмжихэд хандив цуглуулах боломжтой. Сурагчид Read-a-thon-ны талаарх мэдээллийг номын санчаас болон анги удирдсан багш нараасаа удахгүй авах болно.

Номтой нөхөрлөх 7 хоногийн үеэр эцэг эхчүүд хүүхдийнхээ ангид ирж төрөлх хэл дээр нь ном уншиж өгч болно. Хэрвээ та энэ арга хэмжээнд оролцох боломжтой бол хүүхдийнхээ ангийн багштай нь холбоо бариарай. 2-р ангийн сурагчид үлгэр, домог судалж байгаа бөгөөд бусад орны үлгэрүүдээс сонсох хүсэлтэй байгаа. Та бүхэн өөрсдийн орны үлгэр домгоос тэдэнд ярьж өгөхийг сонирхож байвал Ms. Dawson-той холбоо бариарай.

**Бага Сургуулийн Эрхлэгч Janice Wiggins**